

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

1. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас 2 дахин буурсан байна. Нийт 76 үйлчлүүлэгч амбулаторийн 8 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Мэс засал судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн
тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэс засал судлал	7	4	16	27
2	Мэдрэл судлал	2	-	13	15
3	Нүд судлал	2	1	8	11
4	Бөөр судлал	-	1	6	7
5	Эмэгтэйчүүд судлал	2	-	4	6
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	-	5	5
7	Зүрхний эмгэг судлал	-	1	3	4
8	Чих хамар хоолойн эмгэг судлал	-	-	1	1
	НИЙТ	13	7	56	76

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр хүлээж байгаа 76 үйлчлүүлэгчийн дийлэнх буюу 74% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлгийн оношилгооны хүлээгдэл мөн 2 дахин буурсан байна. Нийт 48 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Үүнд: хэвлийн эхо-д харуулахаар 24, рентген оношилгоо хийлгэхээр 13, MRI оношилгоо хийлгэхээр 11 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна.

Шинжилгээ өгөхөөр нийт 28 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 18 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл маш ихтэй байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 445 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 55 үйлчлүүлэгчээр буурчээ. Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 159 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	10	59	90	159
2	Чих, хамар, хоолой судлал	-	20	32	38	90
3	Уламжлалт эмчилгээ	19	19	30	-	68
4	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	12	21	10	9	52
5	Мэс засал судлал	6	15	12	-	33
6	Зүрх судасны эмгэг судлал	9	15	-	-	24
7	Урологи	6	8	-	-	14
8	Мэдрэл судлал	5	-	-	-	5
	НИЙТ	57	108	143	137	445

Мөн Чих, хамар, хоолой судлалын тасагт хэвтэхээр 90, Уламжлалт эмчилгээ хийлгэхээр 68 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байна.

2. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 143 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх саруудаас харьцангуй хүлээгдэл ихтэй байна. Хүүхдийн гэмтэл согогийн кабинетэд үзүүлэхээр 103 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарна./ Хүснэгт 3/

Хүснэгт 3. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хүүхдийн гэмтэл согогийн кабинет	31	19	53	103
2	Сэргээн засахын кабинет	2	1	13	16
3	Насанд хүрэгсдийн гэмтэл согогын кабинет	5	1	2	8
4	Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын кабинет	5	-	2	7
5	Хүзүү нуруу нугасны кабинет	3	2	2	7
6	Цээж хэвлийн гэмтлийн кабинет	-	-	-	1
7	Түлэнхий нөхөн сэргээн мэс заслын кабинет	1	-	-	1
	НИЙТ	46	23	72	143

Тус эмнэлэгт MRI оношилгоо хийлгэхээр 75 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх саруудын хүлээгдлээс огцом буурсан, хүлээгдэл харьцангуй багассан харагдаж байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байв.

3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас нилээн буурсан үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар нийт 14 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 8 3үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ижил түвшинд байна. 2 үйлчлүүлэгч 3-6 хоног, 21 үйлчлүүлэгч 7-14 хоног, 60 үйлчлүүлэгч 15-30 хоног тус тус ор хүлээж байна. Оношилгоо болон лабораторийн тусламж үйлчилгээ хүлээгдэлгүй байна.

4. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх сарын адилаар хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 166 үйлчлүүлэгч 3-6 хоног, 113 үйлчлүүлэгч 7-14 хоног, 12 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 291 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сараас 35 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

5. Хүрээ амаржих газар

Тус эмнэлэг амбулатори, лаборатори, багажийн шинжилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй ажиллаж байна.

6. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Амгалан, Өргөө АГТМЭ, газар, Геронтологийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.